

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЭНХЦЭЦЭГ

ШАРЫН ГОЛ СУМЫН ДУЛААНЫ СТАНЦЫН ШИНЭЧЛЭЛ ХИЙХ  
ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2020.01.20

Шарын гол сум

1.Үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>• Эрчим хүчиний үйлдвэрийн найдвартай ажиллага болон өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний тухай Монгол улсын засгийн газрын тогтоол</li><li>• Компанийн 2020-2025 онд хэрэгжүүлэх хэтийн төлөвлөгөө</li><li>• Шарын гол сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li></ul>
2.Үйлдвэрлэл, аж ахуйн үндсэн чиглэл	Дулааны эрчим хүчиний эх үүсвэр, дулаан хангамжийн систем
3.Байршил	Дархан Уул аймаг, Шарын гол
4.Хүчин чадал	Шарын гол сумын дулааны эрчим хүч хэрэглэгчдийн ачаалал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж тооцоолох, халаалтын бус улиралд хэрэгцээний халуун үс өгөх зориулалтын бага хүчин чадлын зуухтай байх
5.Үйлдвэрлэлийн түүхий эд, материал, ажиллах хүчиний хангамж, эх үүсвэр	Дулаан үйлдвэрлэх эрчим хүчиний анхдагч неец нь Шарын голын нүүрс байна. Компанийн ажиллах хүчин байна
6.Технологийн горимын үндсэн шаардлага	Байгаль орчинд серег нөлөөлөл бага, эрчим хүчиний үр ашигтай техник технологи сонгох
7.Бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлага	Халаалтын улиралд сүлжээний усны температурын горим 130/70 Халаалтын бус улиралд хэрэгцээний халуун усны температур 60-65 км Сүлжээний насосны хүчин чадлыг сонгоходоо сүлжээний гидравлик горимын тооцоог үндэслэнз.
8.Ажиллах горим	Халаалтын ачааллын ажиллагааны горим: 9 дүгээр сарын 15-наас дараа оны 5 дугаар сарын 15 хүртэл 24 цагаар Хэрэгцээний халуун ус хангах ажиллагааны горим: жилийн туршид 24 цагаар
9.Барилга, байгууламжийн бүрэлдэхүүн	Дулааны станц, дулаан дамжуулах төв, тэдээрийн иж бурдэл
10.Инженерийн байгууламж, түүнийт хангах эх үүсвэр	Ус хангамж, цахилгаан хангамж, холбоо дохиолол, бохир ус татан зайлзуулах талаар шаардлагдах тооцоог хийж төвлөвлөнө.
11.Үйлдвэрлэл, аж ахуйн хоршилт, төрөлжилт	-

12.Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	Дулааны станцуу орох гарах асфальтан зам, талбай төлөвлөнө.
13.Захиалагч байгууллага	"Дулаан Шарын гол" ТӨХК
14.Зургийн байгууллага	Эрчим хүчиний барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий этгээд
15.Барилгын байгууллага	Эрчим хүчиний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл бүхий этгээд
16.Техник эдийн засгийн үндэслэл зохиох хугацаа	Гэрээнд заасан хугацаагаар
17.Галын аюулгүй байдлын нөхцөл	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал-БНБД 21.01.02, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм –БНБД 21.02.02 болон бусад холбогдох стандарт, норм, дүрэм
18.Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>• Газар хөдлөлтийн балл: Геологийн дүгнэлтээр</li> <li>• Гадна агаарын тооцоот температур /цаг уурын мэдээллийн сангийн үзүүлэлтээр тооцох</li> <li>• Хур тундасны үзүүлэлтийг харгалzan үерийн усны хамгаалалтыг төлөвлөх</li> <li>• Инженер геологийн дүгнэлтийг үндэслэн хөрсний усны хэлбэлзэлээс үүсч эрсдлийг тооцоолон хамгаалах арга хэмжээнүүдийг холбогдох норм, дүрэм, зааврын дагуу төлөвлөх</li> <li>• Дулааны станцын барилга, дулааны шугам сүлжээний төлөвлөлтийг * Эрчим хүчиний шугам сүлжээ хамгаалах дүрэм*-ийн шаардлагын дагуу төлөвлөх</li> <li>• Аваар ослын үед аврах гарц төлөвлөх</li> <li>• Гадна, дотор шугам сүлжээ, системийн угаглая, шахалт, туршилт тохируулын зардлыг төсөвт тусгах</li> <li>• Ажлын зээлхүүнд тусгагдсан бусад шаардлагын хангах</li> </ul>
19.Техник эдийн засгийн үндэслэл зохиоход ашиглах материал	<ul style="list-style-type: none"> <li>• Шарын гол сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> </ul> <p><u>Одоо хүчин төвэлдээр мөрдөгдж буй</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчин тухай хууль, Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжкууд</li> <li>• Үйлдвэрлэлийн барилгын стандарт, норм,</li> </ul>

	дүрмүүд, Дулааны сүлжээ тоноглолын стандарт, норм, дүрмүүд, Цахилгаан байгууламжийн стандарт, норм дүрмүүд. Ажлын байрны эрүүл ахуйн стандарт, норм, дүрмүүд, Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм, Усын ба усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх ашиглах дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрэм, бусад холбогдох стандарт, норм, дүрмүүд
20.Бусад	Хавсралтаар өгөгдсөн ажлын ззэлхүүн энз даалгаврын бүрдэл хэсэг болно.

БОЛОВСРУУЛСАН:

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Л.НАРАНГЭРЭЛ

## АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН

Дархан –Уул аймгийн Шарын гол сумын дулааны станцыг өргөтгөж шинэчлэх техник здийн засгийн үндэслэлийг боловсруулахдаа дор дурьдсан ажлын хүрээг хамрах ба шаардлагатай нэмэлт ажлуудыг гүйцэтгэн. Үнд:

Нэг. Шарын гол сумын одоо байгаа дулаан хангамж, дэд бүтэц, байгаль орчны болон бусад шаардлагатай тооцоо судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж, станцыг өргөтгөж шинчилснээр байгаль орчинд нөлөөлех нөлөөлөл, нийгэм здийн засгийн байдалд гарах үр дүнг тооцно.

- 1.1 Шарын гол сумын дулааны ачааллын одоогийн болон ирээдүйн өсөлтийн судалгаа тооцооллыг үндэслэн төлөв байдлыг хянаж тодорхойлох, 10-15 жилийн хөгжлийн төвлөй тодорхойлох.
- 1.2 Одоо ашиглак байгаа дулааны станц, дулааны шугам сүлжээ, хэрэглэгчдийн халаалт, хэрэгцээний халуун усны ачаалал, хэрэглээг тодорхойлох
- 1.3 Одогийн төвлөрсөн дулаан хангамжийн системийн гидравлик тооцог хийх.
- 1.4 Хэрэглэгчдийг бүзглэн дулаан дамжуулах төвлөрсөн чадлыг тооцож төлөвлөх.
- 1.5 Гидравлик тооцог үндэслэн сүлжээний усны болон нэмэлт усны наосыг сонгох
- 1.6 Хэрэгцээний халуун усны системд үнэлгээ ёгч, хэрэгцээний халуун ус хангамжийн эх үүсвэрийн шийдлийг тодорхойлох

Хоёр. Дулааны станцын газрын байршилыг өргөтгөлийн барилгын газрыг ашиглан барихаар, дулааны станциад ашиглах түлш ба ус, цахилгаан хангамжийн одоо байгаа хангамжаар төлөвлөх

Гурав. Дулааны станцын хүчин чадал, станцын үндсэн тоноглолтыг оновчтой сонгохын тулд дараах тооцог хийж дүгнэлт гарган олон улсын стандартад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, техник технологийн сонголт хийнз

- 3.1 Дулааны станцын үйлдвэрлэх дулааны тоо хэмжээ
- 3.2 Шарын голын нүурсний чанарт тохирсон зуухны тооцоо, сонголт
- 3.3 Зуухны төрөл ба хүчин чадал, агаарт хаягдах хийн агууламжийн хэмжээг бууруулах, ашигт үйлийн итгэлцуурийг өндөр байлгах, технологийн шийдлүүдийг харьцуулж үзэх, нүүр шатаах технологийн харьцуулалт хийх
- 3.4 Туслах тоноглолтын сонголт тооцоо, төрөл ба хүчин чадал
- 3.5 Цахилгаан хангамжийн схем, цахилгаан тоноглолт
- 3.6 Түлш бэлтгэх дамжлагын технологийг одоо байгаа схемээр автоматуулах
- 3.7 Үнс зайлшуулах технологи, хаягдал үнсийг дахин ашиглах 2-оос доошгүй технологи санал болгох, харьцуулалт хийх, хуурай үнсийг шигшиж ууталж боловсруулах төхөөрөмж сонгох
- 3.8 Утасны хийн цэвэрлэгээний байгууламж, SO<sub>2</sub>, NO<sub>x</sub>, CO<sub>2</sub>-ийг бууруулах технологийн сонголтыг евро стандартын түвшинд шийдэх
- 3.9 Удирдлага ба хяналтын систем
- 3.10 Техникийн агэгдлүүд
- 3.11 Станцын ерөнхий план ба тоноглолын байршил
- 3.12 Станцын өргөтгөлийн гол корпусын барилгын ерөнхий шийдэл, үндэслэл
- 3.13 Станцын техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд /жилд үйлдвэрлэх дулааны эрчим хүч, суурилгадсан хүчин чадал ашиглах цаг гэх мэт/

**3.14 Дулааны станцын техник технологийн сонголтыг оновчтой хийх, дулаан техникийн технологийн шийдлийг гаргах**

**Дареев.Дулаан дамжуулах төвийн тоноглолыг оновчтой сонгохын тулд дараах судалгаа, тооцоог хийж дүгнэлт гарган олон улсын стандартад нийцсэн техник технологийн сонголт хийнэ.**

- 4.1 Хэрэглэгчийн байршилын схем, халаалт, хэрэгзэний халуун усны ачааллын хуваарилалт
- 4.2 Дулаан дамжуулах, түгээх шугамуудын урт, хүчин чадлын тооцоо
- 4.3 Дулаан дамжуулах төвийн хүчин чадал
- 4.4 Дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн сонголт, техникийн шийдэл
- 4.5 Дулаан дамжуулах төвийн технологийн схем

**Тав. Байгаль орчин хамгааллын талаар дараах судалгааг гаргаж үнэлгээ өгсөн байна.**

- 5.1 Агаарын бохирдол
- 5.2 Ус хөрсний бохирдол
- 5.3 Үнс, тоосны хаягдал, хөрсний бохирдол
- 5.4 Дуучимзээ
- 5.5 Утааны хийн хэмжээ агуулга

**Зургаа. Хөрөнгө оруулалтын тооцоо, хөрөнгө оруулалтын үр ашгийн үнэлгээ хийнэ.**

Хөрөнгө оруулалтын тооцоонд дулааны станц, дулаан дамжуулах төвийн үндсэн, туслах тоног төхөөрөмжийн үнэ, барилга угсралтын ажлын зардал, туршилт тохишуулга, хүлээлтн өгөх ажлын зардлууд, станцын үйл ажиллагааг зүгшүүлэх, жигдүүлэх ажлын зардлууд, зөвлөх үйлчилгээний болон техник хяналтын зардлууд, шаардлагатай бол зээлийн хүүгийн зардал, магадлашгүй ажлын зардлуудыг бүрэн тусгах

**Долоо.Санхүү эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийнэ**

- 7.1 Дулааны станц, дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлын төсөөтөртийн тооцоо
- 7.2 Шаарддагдах хөрөнгө оруулалт, туунийг нехех хугацаа, ашиглалт ба засварын зардлын тооцоо үр ашиг, нэгжийн өөрийн өргөт, хувьсах болон тогтмол зардал
- 7.3 Тооцооплын үндсэн дээр төслийг хэрэгжүүлэх арга замыг тогтоохын зэрэгцээ, хөрөнгө оруулалтын ямар арга замавар хийвэлт оновчтой байх саналыг дэвшүүлэх
- 7.4 Хөрөнгө оруулалтын үр өгөөжийт үнэлнэ

**Найм. Техник эдийн засгийн үндэслэлийн баталгаажуулалт.**

- 8.1 Техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчиний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баттуулна
- 8.2 Хурлаас гарсан шийдвэрт үндэслэн стандартын шаардлага хангасан хяналтын төсөө боловсруулна
- 8.3 Шаардлагатай тохиолдолд энэхүү ажлын даалгаврын ТЭЗҮ, хяналтын төсөөволовсруулахад хамаарах хэсэгт нэмэлт, тодоттол хийж болно.

**Ес.Дүгнэлт, санал боловсруулна.**

Тооцоо, судалгаа, үнэлгээний үр дунгүүдэд тулгуурлан төслийг хэрэгжүүлэх оновчтой хувилбарын томъёолохын зэрэгцээ уг төслийг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй хундрэлүүдийг зөв тодорхойлж, түүнийг арилгах даван туулах арга замуудыг зааж өгөх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх саналыг дэвшүүлнэ.

**ТАНИЛЦСАН:**

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /  Б. ЭНХЦЭЦГ

**БОЛОВСРУУЛСАН:**

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР /  Л. НАРАНГЭРЭЛ

